



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/345

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоол, 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоол, 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 5 дугаар хуралдааны 5/03 дугаар тогтоол, 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 6/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Багш" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан Ерөнхий боловсролын 3 сургуулийн бага ангид байгалийн ухааны AR кабинет нийлүүлж, технологийг хэрэглэх арга зүйд багшийг суралцуулах зардалд 10500000 /Арван сая таван зуун мянган/ төгрөг, Кабинетын орчин нөхцөл сайжруулах арга хэмжээний зардалд 7000000 /Долоон сая/ төгрөгийг зарцуулсугай.

2.2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн "Хуваарилалт хийх тухай" А/306 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтад заасны дагуу нийт зардал 17500000 /Арван долоон сая таван зуун мянган/ төгрөгийг "Багш" дэд хөтөлбөрийн 2017 оны төсвийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc

0200001590